

**БУЛГАН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2024.12.10

Булган сум

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хэрэгжилт	Хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1 "Алсын хараа 2050" бодлогын баримт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1.1	Хүүхдийн сэргийлж болох эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, нялхасын болон 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах	-	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин Эцэг, эх, асран хамгаалагч нарт зохион байгуулсан сургалтын тоо	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин-20.0 Эцэг, эх, асран хамгаалагч нарт зохион байгуулсан сургалтын тоо-0	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин-18.6 Эцэг, эх, асран хамгаалагч нарт зохион байгуулсан сургалтын тоо-4	<ul style="list-style-type: none"> Хүүхдийн сэргийлж болох эндэгдэлд нөлөөлж буй хүчин зүйлийг бууруулах чиглэлээр тандалт судалгаа хийж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/263 дугаар тушаалыг баримтлан улирал бүр эндэгдлийн шалтгаан нөхцлийг хэлэлцэж, үнэлгээ дүгнэлт хийж, Эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн ажилласан. Бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх, болон амны хөндийн эрүүл мэнд, нярай хүүхдийн асаргаа, амьсгалын замын цочмог халдвар, суулгалт өвчнөөс сэргийлэх зэрэг сэдвүүдээр эцэг, эх, асран хамгаалагчдад сургалт зохион байгуулах 34 сургагч багшийг бэлтгэсэн. Сургагч багш нар 10 удаагийн сургалтыг зохион байгуулж, төрийн байгууллагын 167 албан хаагч, 109 өрхийн 391 эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулж, 456 гарын авлага материалыг түгээсэн байна. ДЭМБ-ын санхүүжилтээр "Өвчтэй болон дутуу, бага жинтэй нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний менежмент", "Эх барих болон хүүхдийн яаралтай тусламж" сургалтуудыг зохион байгуулж, ЭМБ-уудын яаралтай тусламжийн бэлэн байдалд үнэлгээ хийж, ажлын байрны дадлага сургалтыг 4 сумын ЭМТ-д бүсчлэн зохион 	90

						<p>байгуулж, нийт 147 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> Аймгийн хэмжээнд 2024 оны 11 сарын статистик мэдээгээр 1-5 насны хүүхдийн эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 1.1 байна. Цаашид хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг эрчимжүүлэн, төлөвлөгөө гарган ажиллаж байна. Нялхсын эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 9.4 байгаа нь өмнөх оны мөн үеэс 60 хувиар буурч, улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна. 	
1.2	МУ-ын таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.2.1	<p>Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд 18-аас дээш насны иргэдийг хамруулах</p>	-	<p>Илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь</p>	<p>Илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь - 41.0 хувьтай</p>	<p>Илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь - 61.0 хувьд хүргэх</p>	<p>Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдвал зохих 61717 хүн амын 26355 буюу 44.3%-ийг хамруулсан. Үзлэг оношлогоонд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 0-5 насны хамралт 75.6%, ✓ 6-17 насны хамралт 79.7%, ✓ 18-30 насны хамралт 19%, ✓ 31-45 насны хамралт 27.3%, ✓ 46-60 насны хамралт 34.7%, ✓ 61-ээс дээш насны хамралт 35.3%-ийг хамруулсан байна. <p>Аймгийн хэмжээний хүн амын дунд хоол боловсруулах замын эмгэг, зүрх судасны эмгэг, шээс бэлгийн тогтолцооны эмгэгүүд тэргүүлэн, зонхилон тохиолдож байна.</p> <ul style="list-style-type: none"> Эрт илрүүлэг үзлэгээр хавдрын сэжигтэй, хавдрын урьдал, үүсгэвэр, уйланхай, урагцаг, чулуу, үрэвсэлтэй 318 тохиолдлыг дээд шатлалын эмнэлэгт илгээсний 16.3%-ийн оношийг баталгаажуулан, 51 тохиолдлыг эмчилгээнд хамруулан, эмчийн хяналтад авлаа. Амны хөндийн үзлэг, оношлогоонд 16872 хүүхдийг хамруулсан, ЕБС-ийн сурагчдын 75%, СӨБ-ын хүүхдүүдийн 66%-д 	100

						<p>өвчлөл илэрсэн ба үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 40 %-ийг бүрэн эмчилсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Эрт илрүүлэг үзлэгт 18-с дээш насны иргэдийн 29,0%-ийг хамруулан, нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдлуудыг эмчийн хяналтад авч, эмчилсэн байна. • Аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамралт 44.3 хувьтай байгаа нь улсын дунджаас 1.5 хувиар дээгүүр үзүүлэлттэй байна. 	
1.2.2	"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ОНТ 10.0 сая	<p>Шүд, амны хөндийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь</p> <p>Шүдний өвлөлийг эрүүлжүүлсэн хувь</p>	<p>0-17 насны 13247 хүүхэд буюу нийт хамрагдвал зохих хүүхдийн 72.0 хувийг хамруулж, Үзлэгээр шүдний өвчлөл илэрсэн хүүхдүүдийн 40.0 хувийг нь эмчилгээнд хамруулсан.</p>	<p>Амны хөндийн үзлэг, оношилгоонд 0-17 насны хүүхдийн 80.0 хувийг хамруулж, Үзлэгээр шүдний өвчлөл илэрсэн хүүхдүүдийн 50.0 хувийг нь эмчилгээнд хамруулна.</p>	<p>• "Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хишиг-Өндөр, Могод, Бугат, Хялганат, Сэлэнгэ, Бүрэгхангай, Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг сумдад явуулын үзлэг зохион байгуулан нийт 1084 хүүхдэд фторт түрхлэг, 414 хүүхдэд хамгаалах ломбо тавьж 479 хүүхдэд шүд авах, 412 хүүхдэд байнгын шүдний ломбо тавих эмчилгээ хийсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн НЭ, сумдын ЭМТ, Мозо дент, Булган дент, Смайл зэрэг шүдний хувийн хэвшлийн эмнэлгүүд хамтран ЕБС-ийн 9612, СӨБ-ын 2270 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Үзлэгээр ЕБС-ийн сурагчдын 75%, СӨБ-ын хүүхдүүдийн 66%-д өвчлөл илэрсэн байна. • НҮБ-ийн Хүн амын сан, Бадрал сан, АШУҮИС-НАСС-тай хамтран Дашинчилэн, Баяннуур, Рашаант, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Орхон суманд 0-16 насны 3906 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, фторт түрхлэг 14014, хамгаалах ломбо 121, хар түрхлэг , шүд авалт 566, ломбо тавих 294 зэрэг эмчилгээг нийт 17056 шүдэнд хийсэн. • Хөтөлбөрийн дүнгээр 0-17 насны 16872 хүүхэд буюу нийт хамрагдвал зохих хүүхдийн 77.2 хувийг үзлэгт хамруулж, өвчлөл илэрсэн хүүхдүүдийн 85.0 хувийг эмчилгээнд хамруулан, 40%-ийг нь бүрэн эмчилсэн байна. 	100

1.2.3	Засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоолоор “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээг 2024 оноос орон даяар хэрэгжүүлэх болсонтой холбоотой хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Сургалтын тоо Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо	Сургалтын тоо- 14 Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо- 6500 Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо	Сургалтын тоо- 15 Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо- 7500 Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо	<ul style="list-style-type: none"> • Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 728 удаагийн танхимын сургалтад 14300 иргэд, сурталчилгаанд давхардсан 42467 тоогоор иргэнийг хамруулж, 14 төрлийн 12600 санамж, 6 төрлийн 4621 зурагт хуудас, давхардсан тоогоор нийт 16 мянга гаруй зөвлөмж, зурагт хуудас, гарын авлагыг иргэд, олон нийтэд түгээсэн. • ЭМБ-ууд нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд 61, нэрэмжит сарын аян-11 удаа зохион байгуулж, 42467 иргэнийг хамруулсан. • Эрүүл мэндийн газрын албан ёсны цахим хаяг www.bu.mohs.gov.mn болон “Булган Эрүүл мэндийн газар” нүүр хуудсаар мэдээллийг хүргэн ажиллаж, Эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 501 мэдээллийг цахим хуудсанд байршуулж, 32694 иргэн хандсан үзүүлэлттэй байна. • “Шүд угаах цаг” зохион байгуулах зөвлөмж бичлэгийг Сайхан Монгол тв-тэй хамтран бэлтгэж цахим сургалтыг ЭМБ-ын дарга, нийгмийн ажилтан, ЕБС-ийн захирал, нийгмийн ажилтан, эмч нарт зохион байгуулсан. • “Булган аймаг: Сурагчид ангидаа шүдээ угаах цагтай боллоо” сэдвээр улсын хэмжээний 23 веб сайт, телевизүүдтэй хамтран мэдээллийг олон нийтэд түгээсэн. 	100
1.2.4	Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн суралцагчийг бүрэн хамруулах, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага,	-	ЭМД-ын ач холбогдлын талаарх сурталчилгааг хүргэсэн иргэдийн тоо Эрүүл мэндийн даатгалд шинээр хамрагдсан иргэдийн тоо	ЭМД-ын ач холбогдлын талаар мэдээлэл, сурталчилгааг 4380 иргэнд тогтмол хүргэж, эрүүл мэндийн даатгалд шинээр 8916 иргэн хамрагдсан.	ЭМД-ын ач холбогдлын талаар мэдээлэл, сурталчилгааг 5000 иргэнд тогтмол хүргэж, эрүүл мэндийн даатгалд шинээр 9000 иргэн хамрагдсан.	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн байгууллагууд цахим хуудсаараа эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааг тогтмол явуулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай авах нөхцлийг бүрдүүлэх талаар нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллаж байна. • Аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг 16 суманд зохион байгуулж ажиллах үеэр 2396 иргэнд ЭМД-ын ач холбогдлыг сурталчлан 	100

	иргэдтэй хамтран ажиллах, эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааг тогтмол хийж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай авах нөхцлийг бүрдүүлж ажиллана					таниулж, 250 гаруй иргэнийг ЭМД-д хамруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлсэн. <ul style="list-style-type: none"> Аймгийн хэмжээнд 2024 онд малчин-2755, оюутан-650, хувиараа хөдөлмөр эрхлэгч-1073 нийт 4478 иргэн ЭМД-д шинээр хамрагдсан байна. ЭМБ-уудын хөтөч сувилагч, эрүүл мэндийн ажилтнууд 481 үйлчлүүлэгчийг ибаримт системээр ЭМД-д хамруулж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай авах нөхцлийг бүрдүүлэн ажилласан. 	
1.3 МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.3.1	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот хөтөлбөр, арга хэмжээг эрчимжүүлэх	-	Арга хэмжээ тус бүрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	8 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт тус бүр 90 хувьтай байна.	8 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.	<ul style="list-style-type: none"> ЭМС-ын тушаалаар батлагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, харьяа ЭМБ-уудыг мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Сар бүр удирдамж хүргүүлэн, зохион байгуулсан ажлын тайланг хүлээн авч, үр дүнг тооцон хэрэгжилтийг ханган ажилласан байна. Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн дундаж 92.1 хувьтай байна. 	100
1.3.1.1	“Эрүүл идэвхитэй амьдрал” арга хэмжээг эрчимжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90%	<ul style="list-style-type: none"> Аймгийн хэмжээнд иргэдийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, бие бялдраа чийрэгжүүлэх 160 гаруй зориулалтын спорт заал, фитнес клуб, спорт холбоод үйл ажиллагаа тогтмол явуулж байна. Энэ жилдээ ЭРҮҮЛ ЖИН ДЭЭ” аяныг зохион байгуулах удирдамж, төлөвлөгөөг 16 сум, 1 тосгоны эрүүл мэндийн байгууллагуудад арга хэмжээнүүдийг зохион байгуулж, төрийн болон төрийн бус 28 байгууллагын давхардсан тоогоор 452 албан хаагч, иргэд хамрагдсан. Аяны хүрээнд “Таргалалтаас урьдчилан сэргийлэх, зохистой хооллолт, хөдөлгөөний ач тус” 	100

						<p>зэрэг сэдвүүдээр 24 байгууллагын 928 албан хаагчдад сургалт зохион байгуулан 190 албан хаагчийн биеийн жингийн индексийг тодорхойлж биеийн онцлогт тохирсон зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> • “Цаг гаргая” аяныг хавар, намар 2 удаа зохион байгуулж Эрүүл мэндийн байгууллагуудын 297 албан хаагчид хамрагдан өглөөний алхалт, тэмцээн уралдаанд амжилттай оролцсон. • “Цаг гаргая” аянд ЭМГ манлайлан оролцож, байгууллага хамт олноороо 2-дугаар байр эзэлж, спорт алхалт, буухиа тэмцээнд 1-р дүгээр байр эзэлсэн. • “Булган Монос” ХХК-ийн 15 жилийн ойн арга хэмжээний хүрээнд төрийн 2, хувийн хэвшлийн 3 байгууллага, эмийн сангуудын ажилтан, албан хаагчтай хамтран явган аялал зохион байгуулж, 86 албан хаагчид оролцсон. • Аймгийн хэмжээнд 0-6 сартай хүүхэд эхийн сүүгээр дагнан хооллолт 88%-тай байна. “Олон нийтэд түшиглэсэн нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө” сургалтыг 24 удаа зохион байгуулж 1256 эрүүл мэндийн ажилтан, хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч нар хамрагдсан. • Төрийн албан хаагчдын хооллолтын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох асуумж судалгааг 79 төрийн албан хаагчаас авч, зөвлөгөө, зөвлөмж өгч, “Тэнцвэртэй хооллолт” сэдвээр 10 байгууллагын 150 гаруй ажилтан албан хаагчдад сургалт мэдээлэл хийсэн. 	
1.3.1.2	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг эрчимжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90%	<ul style="list-style-type: none"> • Аймгийн Засаг даргаар ахлуулсан “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-ийг 16 гишүүнтэй байгуулан ажиллуулж байна. • Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тусламж үйлчилгээнд эмэгтэйчүүдийн дурангийн мэс 	90

					<p>засал, гистеросальпингографийн шинжилгээ хийж эхэлсэн. Бөөр шээсний замын (урогинекологийн) мэс заслын дурангийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдаж, аймгийн НЭ-т эмэгтэйчүүдийн дурангийн мэс засалд 3, гистеросальпинго графи шинжилгээг 3 удаа хийж нийт 6 эмэгтэйд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн.</p> <ul style="list-style-type: none">• НҮБ-ын ХАС-ын дэмжлэгтэй “Сэргийлэх боломжтой эхийн болон перинаталь эндэгдлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх” төслийн хүрээнд Тэшиг, Рашаант сумдын ЭМТ-үүдэд эх, хүүхдийн тусламж, үйлчилгээний алсын зайн оношилгооны телемедицинийг шинээр нэвтрүүлсэн.• Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр ДЭМБ-ын санхүүжилтээр “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулснаар тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх эх, нярай, хүүхдийн эндэгдлийг бууруулах төсөл”-ийн хүрээнд 48 нэр төрлийн 410 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдсан.• Түнхний дутмаг хөгжлийн илрүүлэг шинжилгээ жил бүр тогтмол хийгдэж, энэ онд 443 нярайг хамруулж, давтан үзлэгт 74 нярайг хамруулан, 14 нярайд дөрөөвч зүүсэн байна.• Эрт илрүүлэх үзлэгт 2024 онд нөхөн үржихүйн насны 920 эмэгтэй хамрагдсан. Үзлэгээр нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дунд шээс, бэлгийн замын өвчлөл, хоол боловсруулах замын өвчлөл, зүрх судасны өвчлөл зонхилон тохиолдож байгааг эмчийн хяналтад авсан байна.• НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэй “Хэрхийн шалтгаант зүрхний өвчнөөс сэргийлэх, түүнийг бууруулах төсөл”-ийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 1-12 ангийн 9993 хүүхдүүдэд А бүлгийн β-стрептококк илрүүлэх шинжилгээг түргэвчилсэн оношлуураар хийж, үүнээс 520 хүүхдийн шинжилгээний хариу эерэг гарч
--	--	--	--	--	--

						эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байна.	
1.3.1.3	“Хавдрын эсрэг” арга хэмжээг эрчимжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90%	<ul style="list-style-type: none"> • Аймгийн Засаг даргын баталсан "Хүрч үйлчилье" аяны хүрээнд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг Могод, Хишиг-Өндөр, Тэшиг, Баян-Агт, Сайхан, Хутаг-Өндөр суманд зохион байгуулж, давхардсан тоогоор 2396 иргэнийг хамруулж элэгний хавдарын сэжигтэй 3, умай, хөхний хавдрын сэжигтэй 20, ходоодны хавдрын сэжигтэй 2, эсийн шинжилгээний өөрчлөлттэй 22, бамбайн хавдарын сэжигтэй 1, хөхний үүсгэвэртэй 15, бөөрний үүсгэвэртэй 3 нийт 66 тохиолдлыг илрүүлэн яаралтай онош тодруулахаар дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэн, 51 тохиолдлыг эмчилгээнд хамруулсан. • Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх 3 сарын аяныг зохион байгуулан, эсийн шинжилгээнд хамрагдвал зохих эмэгтэйчүүдийг 67% буюу 2773 хүнийг хамруулсан. Үзлэг, оношлогоогоор өөрчлөлт илэрсэн 42 эмэгтэйг дээд шатлалд илгээсэн байна. • Элэг, ходоод, уушгины хавдраас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх аянуудыг зохион байгуулан 1725 иргэнийг эрт илрүүлэх үзлэгт, 5503 иргэнийг элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулан, элэгний В вирус сөрөг гарсан 735 хүнийг сайн дурын дархлаажуулалтад хамруулсан. • Хөхний өмөн илрүүлэх үзлэгт нийт 9699 эмэгтэй буюу хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн 63.4%-ийг хамруулсан. • Хорт хавдар өвчтэй 675 иргэн, тэдний ар, гэр, асран халамжлагч 486 хүн, амбулаториор үйлчлүүлсэн 506 иргэнд “Хавдрын өвчний сэтгэл зүй, сэтгэл засах, асаргаа сувилгаа”-ны талаар, зөвлөгөө, мэдээллийг өгч, 9 төрлийн гарын авлага бэлтгэн тарааж, сургалт, нөлөөллийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. 	100

						<ul style="list-style-type: none"> • Нийт Эрүүл мэндийн байгууллагууд хөнгөвчлөх тусламж үйлчилгээг амбулаториор давхардсан тоогоор 1465 иргэнд, стационариар 360 иргэнд, сувилахуйн тусламж үйлчилгээг гэрээр 2471 иргэнд тус тус үзүүлсэн. Гэрээр тусламж үйлчилгээ авсан нийт иргэдийн 11.4 хувь нь 4, 5-р бүлгийн иргэд, 45.0 хувь нь ахмад настнууд байсан байна. 	
1.3.1.4	“Харшлаас сэргийлэх” арга хэмжээг эрчимжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90%	<ul style="list-style-type: none"> • ЭМЯ, НЭМҮТ-өөс Харшлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан 2 төрлийн постор, 1 төрлийн шторкийг Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсанд байршуулан сурталчилж нийт 8145 цахим хандалт авч, Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлж буй 1448 гаруй иргэнд зөвлөмж мэдээлэл хүргэсэн. • НЭМҮТ, Иргэдийн хэрэглээний боловсролын төвүүдтэй хамтран “Эрүүл амьдралын зөв дадал зуршил, сэтгэл зүйн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал” сэдэвт сургалтад 16 суманд зохион байгуулан 800 гаруй иргэнийг хамруулсан. • Нялх, балчир насны хүүхдийн хүнс, түүний найрлага, сав, баглаа боодол, шошгод урьдчилан сэргийлэх хяналтыг худалдааны төв, супермаркет, дэлгүүр, 10 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, харшил үүсгэдэг үр тариа түүгээр хийсэн бүтээгдэхүүн, шар буурцаг түүгээр хийсэн бүтээгдэхүүн сүү сүүн бүтээгдэхүүний орц найрлагын талаар заавар, мэдээлэл, сурталчилгааг худалдаа үйлчилгээний байгууллагын 15 ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө заавар өгч, ажилласан. • Эмийн харшлаас сэргийлэх талаарх иргэдийн эрүүл мэндийн боловсролд мэдлэг олгох сургалт сурталчилгааг Эм холбоотой хамтран 2 удаа “Нээлттэй хаалганы өдөр”-ийн зохион байгуулж 145 гаруй иргэнд мэдээлэл хүргэсэн. 	90

						<ul style="list-style-type: none"> • Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхээр “Эмийн харшил, гаж нөлөө” сэдвээр Нэгдсэн эмнэлгийн тасгуудад хэвтэн эмчлүүлэгч нарт давхардсан тоогоор 1485 иргэнд сургалт мэдээлэл хийсэн. • Харшилтай тэмцэх Дэлхийн долоо хоногийг жил бүрийн 04-р сарын 8-16-ны хооронд тэмдэглэн өнгөрүүлж, харшлын талаар иргэдэд зөв мэдээлэл олгох сургалт, сурталчилгааны ажлыг жил бүр зохион байгуулж байна. Нийт 345 гаруй иргэнд мэдээлэл хүргэсэн байна. • Монгол Улсын ерөнхийлөгчийн 58 дугаар зарлигаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэн аймгийн хэмжээнд энэ онд хавар, намрын улирлын тариалалтаар 13 төрлийн 654.000 гаруй мод бутыг тарьж ургуулсан. 	
1.3.1.5	“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг эрчимжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90%	<ul style="list-style-type: none"> • Эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд нийт үзлэгт хамрагдвал зохих 61717 иргэдээс 26231 буюу 44%-ийг хамруулаад байна. Нийт хамрагдсан иргэдийн 47.1%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна. • Урологийн кабинетаар 2024 онд 1439 хүнд үзлэг хийн 955 өвчлөл бүртгэсэн байна. Мэс заслын тасагт урологийн хэсэгт 73 хүн хэвтэн эмчлүүлж, 22 хүнд мэс засал хийж, 42 хүнд едрийн эмчилгээ хийсэн. • Зүрх судасны өвчлөлийн шалтгаанаар амбулаториор 3609 хүн үйлчлүүлсэн үүнийн 38.15% буюу 1377 нь эрэгтэйчүүд эзэлж байна. • Эрэгтэйчүүдэд зонхилон тохиолдож буй зүрх судасны өвчлөл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж байна. Тус үйл ажиллагааны хүрээнд “Архи тамхитай тэмцэх сар”-ын аяныг зохион байгуулж архи тамхины хор уршгийн талаар зөвлөмж мэдээллийг олон нийтэд түгээж 635 хүнийг хамруулсан. 	90

						<ul style="list-style-type: none"> • 2024 онд 54 иргэн архины эмчилгээнд хамрагдаж урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд оруулсан эмчлэн эрүүлжүүлэх нийгэмшүүлэх болон харшил үүсгэх эмчилгээ болон ганцаарчилсан, бүлгийн сэтгэл засал эмчилгээ хийж ажилласан. • Осол гэмтлээс сэргийлэх зөвлөмж, замын хөдөлгөөний аюулгүй байдал, дасгал хөдөлгөөний ач тус, сэтгэцийн эрүүл мэнд, есвөр насны эрэгтэй хүүхдийн хоол тэжээлийн талаар зөвлөмжийг боловсруулж, олон нийтэд цаасан болон цахим хэлбэрээр түгээх, сургалт зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэн давхардсан тоогоор 1107 хүнийг хамруулсан. 	
1.3.1.6	“Элэг бүтэн Монгол” арга хэмжээг эрчимжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90%	<ul style="list-style-type: none"> • “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Гепатитын халдварын эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт сэдэвт сургалтыг нийт ЭМБ-уудын 36 эмч, лаборант нарт зохион байгуулсан. Тус сургалтад хамрагдсан эмч нар өөрийн байгууллага дээр дотоодын сургалтыг хийж аймгийн хэмжээнд 561 эмч, эмнэлгийн мэргэжилтэн сургалтад хамрагдсан байна. Мөн багийн хурал, өдөрлөгийн үйл ажиллагаанд оролцсон иргэд болон явуулын үзлэгт хамрагдсан 865 иргэнд сургалт, сурталчилгааг зохион байгуулж 1125 гарын авлага, сурталчилгааны материал тараасан. • Элэг бүтэн Монгол арга хэмжээний хүрээнд улсын төсвөөр АНЭ-т 13.350.000 төгрөгний гепатитын дельта вирус илрүүлэх Элиза аппарат, 11.300.000 төгрөгний гепатитын В, Д вирус илрүүлэх, тоолох оношлуур, анхан шатны ЭМБ-уудад 14.315.000 төгрөгний 20450ш гепатитын В вирус илрүүлэх түргэвчилсэн оношлуурыг хувиарлан олгосон. • Эрт илрүүлэх үзлэгийг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт хамрагдвал зохих иргэдийн 20 хувийг буюу 7209 иргэнийг 	100

						<p>гепатитын В, С вирус илрүүлэх оношилгоонд хамруулж гепатитын С вирусийн архаг халдварын шинэ 13 тохиолдол, В вирусийн архаг халдварын шинэ 6 тохиолдлыг вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээнд хамруулж 18 иргэнийг эмчилгээнд хамруулсан байна.</p> <ul style="list-style-type: none"> • Жирэмсний хяналтад байгаа гепатитын В вирусийн халдвартай 13, С вирусийн халдвартай 3 эхийн бүртгэл мэдээлэл, эмчилгээ, хяналтын тогтолцоонд дэмжлэгт хяналтыг хийсэн. Гепатитын В вирусийн халдвартай эхээс төрсөн 6 сартай нэг хүүхдийг элэгний В вирус илрүүлэх, дархлал тогтоц тодорхойлох шинжилгээнд хамруулахад вирус илрээгүй ба В вирусийн эсрэг дархлал тогтсон байна. • Энэ онд В вирусын халдвартай 8 эхээс төрсөн нярайг вирусын эсрэг иммуноглобулин, В гепатитын эсрэг вакцинд 100 хувь хамруулсан. • Гепатитын С вирус дарангуйлах эмчилгээнд шинээр 20 хүн хамрагдаж ледвир, гепатитын В вирусийн эм 2024 онд шинээр 3 хүн нийтдээ 280 хүн ууж байна. • Бугат, Бүрэгхангай сумдад 431 иргэнийг В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад хамруулсан. 	
1.3.1.7	“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээг эрчимжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90%	<ul style="list-style-type: none"> • Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 8 зорилт 67 арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 11 сард 12 төрлийн 333 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн нь 10,000 хүн амд 55.1 промилль байна. Нийт бүртгэгдсэн халдварт өвчний 213/64%/-ийг амьсгалын замын халдварт өвчин, 62/18.6%/-ийг бэлгийн замын халдварт өвчин, 37/11.1%/-арьсны халдварт өвчин тус тус эзэлж, өмнөх оны мөн үеэс 54 тохиолдолоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 	100

						<ul style="list-style-type: none"> • Аймгийн хэмжээнд томуу томуу төст өвчин болон коронавирусын халдварыг 7 хоног тутам харуулдан тандалтын нэгжүүдээр, бусад халдварт өвчний тандалтыг эрт сэрэмжүүлэх хариу арга хэмжээний тогтолцоогоор тус тус дамжуулан тандалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. • Сүрьеэ өвчнийг илрүүлэх үзлэгт 604, БЗДХ-аас сэргийлэх илрүүлэг үзлэгт 1256, кабенитийн үзлэгээр 2703 хүнийг хамруулж, тэмбүү 24, заг хүйтэн 22, трихоминоз 10, бэлгийн мөөгөнцөр 27 шинээр илрүүлж, эмчлэн эрүүлжүүлсэн. • Халдварт өвчний чиглэлээр эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадваржуулах цахим сургалтыг 6 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 228 эмнэлгийн мэргэжилтэнийг хамруулсан. • Иргэд олон нийтэд чиглэсэн халдварт өвчнөөс сэргийлэх сургалтыг 3 удаа зохион байгуулж, 24 иргэнийг, сурталчилгааг 54 удаа хийж, 406 иргэнийг тус тус хамруулсан. Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар халдварт өвчнөөс сэргийлэх талаарх 8 төрлийн зурагт хуудас, анхааруулга, мэдээлэл зөвлөмжийг 72 удаа түгээсэн. • Хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын 3 сарын нөөцийг бүрдүүлсэн. Заавал хийх дархлаажуулалтын хамралт 97.8 хувьтай байна. 	
1.3.1.8	“Орчны эрүүл мэнд” арга хэмжээг эрчимжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90%	<ul style="list-style-type: none"> • Томуу, томуу төст өвчний дэгдэлтэд эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудад 3 удаагийн цахим хурлыг зохион байгуулж, 48 удаа эрсдэлийн үнэлгээ хийж, эргэн мэдээлэл боловсруулан хариу арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан. Томуугийн эсрэг дархлаажуулалтад нийтдээ 3630 хүнийг хамруулсан. 	100

					<ul style="list-style-type: none"> • Орчны эрүүл мэндийн талаар иргэдийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор дотоод орчны бохирдол, нүхэн жорлон, уур амьсгалын өөрчлөлт, тасалгааны ургамал, хөрсний бохирдлын талаар цаасан болон цахим хэлбэрээр зөвлөмж мэдээлэл хүргүүлэх, сургалт зохион байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэн нийтдээ давхардсан тоогоор 3686 хүн хамрагдсан. • Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд богино хэмжээний 3 геел бэлтгэн 2774 хүнд хүргэсэн. • Нүхэн жорлон, угаадасны нүх MNS 5924:2014 стандартыг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 632 хүнд зөвлөмж мэдээлэл түгээж, 226 айлын нүхэн жорлонг үнэлж, стандартыг таниулах ажлыг зохион байгуулж тус ажлын үр дүнд шаардлага хангахгүй 12 айл нүхэн жорлонгоо сайжруулсан. • ЭМС-ын 2017 оны А/505 тушаалын дагуу эмнэлгийн хог хаягдлыг устгаж, халдваргүйтгэх, тээвэрлэж байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр 74.8 сая төгрөгийн аюултай хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэх автоклавыг аймгийн Нэгдсэн эмнэлэгт суурилуулсан. Эмнэлгийн хог хаягдлыг устгах, халдваргүйтгэх, тээвэрлэх зааварчилгааг 19 эрүүл мэндийн байгууллагын ажилчдад цахимаар зохион байгуулж нийт 163 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. • ЭМГ-ын дэргэдэх ахуйн мэрэгч устгал, халдваргүйжүүлэх үйлчилгээний цэг 90 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж, 40226 м2 талбайд халдваргүйтгэл, мэрэгчгүйтгэл, шавжгүйтгэл хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтгэл хийх 7 ариутгагчийг ажлын байрны богино хэмжээний сургалтад хамруулсан.
--	--	--	--	--	---

1.4 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.4.1	Дашинчилэн сумын эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барихад орон нутгийн оролцооны хөрөнгийг шийдвэрлүүлэх	ОНТ-602.0 сая	ЭМТ-ийн шинэ барилгын дэд бүтэц шийдэгдсэн байх	Дашинчилэн сумын ЭМТ-ийн барилгын дэд бүтцэд шаардлагатай 602,0 сая төгрөг шийдвэрлэгдсэн.	Дашинчилэн сумын ЭМТ-ийн барилгын дэд бүтцийг ашиглалтанд өгсөн байна.	<ul style="list-style-type: none"> “Азийн хөгжлийн банк”-ны төслөөр хэрэгжүүлж байгаа Дашинчилэн сумын 15 ортой Эрүүл мэндийн төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Цомбон тоосго” ХХК шалгарч, барилгын ажил 60%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Орон нутгийн төсвийн 602.0 сая төгрөгийн санхүүжилтаар тендер зарлаж шалгарсан “Бурхуд” ХХК нь тус барилгын /дулаан хангамж, цахилгаан хангамж, цэвэр ус, бохир/-ын дэд бүтцийн ажлыг 100% хийж гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн. 	100
1.4.2	Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж, бүрэн камержуулан аюулгүй байдлыг сайжруулах	АХБ-502.0 УТХО-700.0	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	Тоног төхөөрөмжийн хангалтыг 89.9 хувьд хүрсэн.	Тоног төхөөрөмжийн хангалтыг 90 хувьд хүргэх	<ul style="list-style-type: none"> Аймгийн эрүүл мэндийн салбарт улсын төсвийн 1401.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт урологийн дурангийн иж бүрдэл багаж тоног төхөөрөмж, чих хамар хоолойн тоног төхөөрөмж, Хишиг-Өндөр, Бугат, Эмийн цэцэглэн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ЭХО аппарат бусад эрүүл мэндийн байгууллагуудад оношилгоо эмчилгээ, яаралтай тусламж, нөхөн сэргээх физик эмчилгээний нийт 16 нэр төрлийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдаж, аймгийн хэмжээнд тоног төхөөрөмжийн хангалт 92.5%-д хүрсэн. Энэ онд Эрүүл мэндийн байгууллагууд 32 камерыг шинээр суурилуулж, байгууллагын гадна, дотор орчин, тасаг нэгжүүдэд үйлчлүүлэгч болон ажилтнуудын аюулгүй байдлыг бүрэн хангасан. 	100
1.4.3	Эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашинаар үе шаттай хангах.	Улсын төсөв 150.0 сая	2 байгууллагыг түргэн тусламжийн автомашинаар хангах	Нэгдсэн эмнэлэг, Сайхан, Тэшиг сумд түргэн тусламжийн автомашинаар хангагдсан байна.	Рашаант, Орхон сумын ЭМТ-үүдийг түргэн тусламжийн автомашинаар хангах	<ul style="list-style-type: none"> Улсын төсвийн 2231.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт бүрэн тоноглогдсон Ford transit маркийн автомашин, Орхон, Бугат сумын ЭМТ-д пургон автомашин, Баян-Агт, Баяннуур, Дашинчилэн, Могод, Рашаант, Сэлэнгэ, Хишиг-Өндөр сумд, Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвүүдэд бүрэн тоноглогдсон “Ланд 78” маркийн нийт 11 автомашинаар хангагдсан. Нийт ЭМБ-уудын 58%-д нь парк шинэчлэлт хийгдсэн. 	100

						<ul style="list-style-type: none"> • Нийт багийн эмч нарыг 100% мотоциклиор хангасан. 	
1.4.4	Сүрьеэ, БЗДХ/ХДХВ, тэмбүү илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн хүн амын хамрагдалтыг нэмэгдүүлнэ	-	Сүрьеэгийн ойрын хавьтлын үзлэгийн хамрагдалтыг хувь БЗДХ, тэмбүү илрүүлэх үзлэг, оношлогоонд хамрагдсан нөхөн үржихүйн насны иргэдийн хамрагдалтын хувь	Сүрьеэгийн 12 шинэ тохиолдол бүртгэгдэж, эдгээрийн ойрын хавьтал болох 75 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. БЗДХ, тэмбүү илрүүлэх үзлэг, оношлогоонд 4091 иргэнийг хамруулснаар нь нөхөн үржихүйн насны иргэдийн хамрагдалтыг 78.5 хувьд хүргээд байна.	Сүрьеэгийн ойрын хавьтлын үзлэгийн хамрагдалтыг 80.0 хувьд хүргэх БЗДХ, тэмбүү илрүүлэх үзлэг, оношлогоонд хамрагдсан нөхөн үржихүйн насны иргэдийн хамрагдалтыг 90.0 хувьд хүргэх	<ul style="list-style-type: none"> • Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар сүрьеэгийн халдварын 22 тохиолдлыг шинээр илрүүлэн, эмчилгээнд хамруулсан. Нийт 79 хавьтлын 69 буюу 87,3%-ийг хавьтлын үзлэгт хамруулж, 9 далд халдварыг илрүүлэн, 3 хүнийг далд халдварын эмчилгээнд оруулж эмчилгээг дуусгасан. 6 тохиолдлыг эмчилж байна. Хавьтлаас хүүхдийн сүрьеэгийн 2 тохиолдлыг эрт илрүүлж хяналтанд авч эмчилсэн. Эдгэрэлт 100% байна. Хялганат суманд гэр бүлийн 2 хүүхэд нян судлалаар батлагдсан уушгины сүрьеэгийн тохиолдол бүртгэгдсэн. Тохиолдолын хавьтал болох 7-9 ангийн нийт 112 хүүхдүүдэд цээжний рентген зурагт хамруулж хавьталын үзлэг хийгдсэн. • Сүрьеэгийн лабораторийн чадавхыг бэхжүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж цэрэнд ХТН илрүүлэх түрхэцийн шинжилгээ болон GeneXpert аппаратаар ХТН илрүүлэх, рифампицин тэсвэржилт тодорхойлох шинжилгээг цаг тухай бүр тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. • Булган аймгийн 16 сумдын лаборант нарт цэрний сорьц тээвэрлэлт болон хадгалалтын талаар сургалт тогтмол хийж эрчимжүүлэн ажиллаж байна. Нийт 312 хүний 624 сорьцонд ХТН илрүүлэх шинжилгээ хийгдсэн. Няан судлалын шинжилгээгээр батлагдсан өсгөвөр эерэг сүрьеэгийн 3 шинэ тохиолдолд эмэнд тэсвэржилтийг тодорхойлсон. Тэсвэржилт илрээгүй. Хутаг өндөр сумын ЭМТ-ийн лабораторит туринат төхөөрөмжөөр 19 хүнд шинжилгээ хийж, 1 эерэг тохиолдол бүртгэгдсэн. • Хишиг-Өндөр, Могод, Хялганат, Хангал, Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг сумдуудад сүрьеэгийн идэвхтэй 	90

						<p>илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, нийт 604 хүнийг үзлэгт хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> Урьдчилан сэргийлэх үзлэгээр БЗДХ илрүүлэх шинжилгээнд 501 иргэнийг хамруулж, тэмбүүгийн 2 тохиолдлыг эмчлэн эрүүлжүүлсэн. 2024 онд 557 жирэмсэн эхийг БЗДХ илрүүлэх шинжилгээнд хамруулж, кабинетаар 2703 хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгч, урьдчилан сэргийлэх үзлэгээр БЗДХ илрүүлэх шинжилгээнд 1256 иргэнийг хамруулсан. БЗДХ/ХДХВ-ын талаар сургалт зохион байгуулах, зөвлөмж мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулж 179 хүн хамрагдсан. 	
1.4.5	“Эрүүл мэнд” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	ОНТ-30.0 сая	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Хөтөлбөрийн хэрэгжилт 90%	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 100% хэрэгжүүлнэ	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн зорилтод эрүүл мэндийн салбарын тулгамдаж буй асуудал болох нялхсын эндэгдэл, сэргийлж болох өвчлөл, эндэгдэл, нас баралтын түвшнийг бууруулах, халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх 5-н зорилтын 30 арга хэмжээг, 27 шалгуур үзүүлэлтийг ханган ажилласан. Хөтөлбөрийн хэрэгжилт 90,0 %-тай байна. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдтэй хамтран зохион байгуулж, нийт хүн амын 44,3 %-ийг хамруулан энэ онд шинээр 162 хорт хавдрын сэжигтэй тохиолдлыг дээд шатлалын эмнэлэгт илгээж, өвчлөлийн 48.1% буюу 78 тохиолдлыг I,II үе шатанд нь оношийг баталгаажуулсан. Халдвар бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралт өмнө оныхоос 2,8 %-иар, хорт хавдар өвчний эрт илрүүлэлт өмнөх оноос 22,9 %-иар нэмэгдэж, сүүлийн 3 жилд хорт хавдар өвчний эрт илрүүлэлт 52,9% болсон байна. Хорт хавдар өвчний 41.9 %-ийг эрчүүдийн өвчлөл эзэлж байна. 	90

						<ul style="list-style-type: none"> Өсвөр үеийн хүүхэд, багачуудын амны хөндийн өвчлөлийг эмчлэн, эдгэрүүлэх ажлын хүрээнд ЭМЯ, аймгийн ЗДТГ-ын НБХ-тэй хамтран 6 сумын ЭМТ-ийг шүдний кабинеттай болгож, боловсон хүчнээр ханган, 90 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэн, 0-17 насны хүүхдүүдийн 77,2 хувийг амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулсан байна. 	
1.4.6	Багийн эмч нарыг “Mobile” тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах	УТ, ОНТ 100.0 сая	“Mobile” тоног төхөөрөмжөөр хангагдсан багийн эмчийн тоо	Мобайл тоног төхөөрөмжөөр хангагдсан багийн эмч байхгүй	12 багийн эмчийг мобайл тоног төхөөрөмжөөр хангана.	<ul style="list-style-type: none"> ДЭМБ-ын санхүүжилтээр Сэлэнгэ сум, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5 сумыг нийт 78. 0 сая төгрөгөөр 6 сумыг мобайл тоног төхөөрөмжөөр хангасан. Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвүүд мобайл технологи ашиглан 653 иргэнд зүрхний цахилгаан бичлэг, 189 иргэнд ЭХО, 478 иргэнд сахар, 389 иргэнд холестрин илрүүлэх шинжилгээг хийсэн байна. Багийн эмч нар мобайл тоног төхөөрөмжийг алслагдсан багийн иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээнд ашиглаж байна. 	70
1.4.7	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг өндөр хөгжилтэй оронд урт болон богино хугацааны сургалтанд хамруулж, туршлага судлуулах	-	Гадаад орны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэ эс туршлага судалсан, сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	Хилийн чанадад болон цахим сургалтанд нийт 6 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.	Хилийн чанадад болон цахим сургалтанд 10-аас доошгүй эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулна.	БНХАУ-д 3 их эмч, 3 бага эмч, БНСУ-д 3 их эмч, Япон улсад 2 их эмч ОХУ-д 1 их эмч, 1 бага эмч нийт 15 эмч, эмнэлгийн мэргэжилтэн 3-21 хоногийн гадаад сургалтад хамрагдсан.	100
1.4.8	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг “CERVICARI AI” аппаратаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулах	-	“CERVICARI AI” аппаратаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	“CERVICARI AI” аппаратаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт 960 эмэгтэйчүүд хамрагдсан.	“CERVICARI AI” аппаратаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийг 1200-д хүргэнэ.	<ul style="list-style-type: none"> Аймгийн хэмжээнд 2024 оны 11 сарын байдлаар 1337 эмэгтэйчүүдийг хиймэл оюун ухаанд суурилсан "CerviCare AI" аппаратаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамруулсан. Үүнээс явуулын үзлэгт 9 сумын 532 эмэгтэй хамрагдсан. Үзлэгээр эд, эсийн шинжилгээ өгөх шаардлагатай 354 эмэгтэйг илрүүлэн эсийн 	100

						шинжилгээ авч онош тодруулах шаардлагатай 24 тохиолдлыг эдийн шинжилгээгээр онош баталгаажуулсан. Үүнээс лийф эмчилгээ-10, хянагдаж эдийн шинжилгээ өгөх - 6, хяналтад байх - 5, лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлсэн - 3 тохиолдол байна.	
1.5	Салбарын сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.5.1	Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх болон осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, авто тээврийн гэх мэт)-д анхаарч салбар дундын хамтын ажиллагааг ханган ажиллана.	-	Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээний тоо	Өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор 4 сэдвийн хүрээнд зохион байгуулалт, уулзалт, ярилцлага 64, тэмдэглэлт өдрүүд 2, нэрэмжит сарын аян 3 удаа, хөдөлгөөнт болон цахим сургалт 168 удаа зохион байгуулж, 5614 сурагчдыг хамруулсан.	Өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор 5 сэдвийн хүрээнд зохион байгуулалт, уулзалт, ярилцлага 65, тэмдэглэлт өдрүүд 2, нэрэмжит сарын аян 3 удаа, хөдөлгөөнт болон цахим сургалт 200 удаа зохион байгуулж, 6000 сурагчдыг хамруулсан.	<ul style="list-style-type: none"> Дэлхийн Сэтгэцийн эрүүл мэндийн өдрийн хүрээнд “Ажлын байран дахь Сэтгэцийн эрүүл мэнд” сэдвээр богино хэмжээний геел бэлтгэн олон нийтэд түгээж 1300 хүнд хүргэсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн кабинетэд 1640 хүн амбулаторийн тусламж үйлчилгээ авсан, 229 хэвтэн эмчлүүлсэн байна. Сэтгэцийн кабинетийн хяналтад нийт 530 сэтгэцийн эмгэгтэй иргэд байна. Өсвөр үеийн сурагчдаас сэтгэл хөдлөл зан үйлийн байдлын судалгааг 447 хүүхдээс асуумж авч үр дүнг боловсруулсан. Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлын үнэлгээгээр нийт судалгаанд хамрагдсан сурагчдын 25.06 хувь нь хэвийн, 39.37 хувь нь зааг, 35.57 хувь нь хэвийн бус гэсэн үр дүн гарсан байна. Энэхүү үнэлгээг согтууруулах ундааны хэрэглээ, тамхины хэрэглээ, цахим орчны хэрэглээтэй харьцуулан үзэхэд сэтгэл хөдлөл зан үйлийн байдал хэвийн бус байх нь дээрх хорт зуршлын хэрэглээ нэмэгдэх тохиолдол ажиглагдсан. Тус судалгааны үр дүнд үндэслэн архи, тамхи, дам тамхидалт, үе тэнгийн дээрэлхэлт, гар утасны хэрэглээ, өсвөр насны хүүхдийн хооллолт, сэтгэл зүй, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хурдан морины унаач хүүхдийн аюулгүй байдлын талаар олон нийтэд цаасан болон цахим хэлбэрээр зөвлөмж мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэн давхардсан тоогоор 6103 хүн хамрагдсан. 	100

						<ul style="list-style-type: none"> ЭМС-ын 2015 оны А/68 дугаар тушаалын дагуу “Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн 600 ширхэг жор хэвлэгдсэн. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Цожэд ӨЭМТ, Эмийн цэцэглэн ӨЭМТ, Сайхан, Дашинчилэн, Хишиг-Өндөр, Баяннуур, Тэшиг, Бугат сумын эрүүл мэндийн төвд 408 ширхэг жорын маягт хувиарласан. Үүнээс 327 жорын маягтанд жор бичиж иргэдэд олгосон байна. 	
1.5.2	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлж байгаатай холбоотой нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллах хүний нөөцийг орон нутагтаа бэхжүүлнэ.	-	Нийгмийн эрүүл мэндийн хүний нөөцийн хангалтын хувь	Нийгмийн эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт 100 хувь	Нийгмийн эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт 100 хувь	<ul style="list-style-type: none"> Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад тус бүр нэг, нэг нийгмийн эрүүл мэндийн ажилтан орон тоогоор ажиллаж байна. Салбарын хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн хүний нөөцийн дутагдал байхгүй бөгөөд 2 мэргэжилтэнг шинээр нийгмийн эрүүл мэндийн мэргэжил олгох сургалтад, 4 сувилагч тусгай мэргэжилтэн нийгмийн эрүүл мэндийн дээшлүүлэх 1 сарын сургалтад хамрагдсан. Нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхижуулах 1 удаагийн цахим, 2 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, 19 нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. Талбарын тархвар судлалаар нэг жилийн сургалтад 1, зургаан сарын сургалтад 1 нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн хамрагдаж байна. 	100
1.5.3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах дэд бүтцийг эрүүл мэндийн байгууллагад бүрдүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл	-	Дэд бүтцийг бүрдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	Орхон сумын эрүүл мэндийн төвийн шинэ барилга гадна налуу шат, Бүрэгхангай, Баян-агт сумын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн 2 тасагт	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж үйлчилгээ авах нөхцлийг сайжруулсан эрүүл мэндийн байгууллагын тоог	<ul style="list-style-type: none"> MNS7014:2023 "ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА" стандартыг хэрэгжүүлэн аймгийн хэмжээнд дохионы хэлээр ойлголцох шаардлагатай сонсгол, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй 175, харааны бэрхшээлтэй 85 иргэнд эрүүл мэндийн 19 байгууллага эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж, чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр анх удаа шинээр санаачлан 76 	100

	авах эрхийг хамгаалж ажиллана.			коридорын хананд бариул шинээр хийн, тохижуулсан.	нэмэгдүүлсэн байна.	дохионы хэлний цагаан толгой, 402 брайль үсгийн хаягжуулалт хийж байршуулсан. <ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн байгууллагуудын 50 төрийн албан хаагчдад “Дохионы хэлний анхан шатны чадвар эзэмшүүлэх нь” сэдэв сургалтыг 8 цаг, 2 ээлжээр онол, дадлага хослон зохион байгуулж, гарын авлага материалаар хангасан. Эрүүл мэндийн байгууллагууд тэргэнцэртэй иргэнд үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэн эмнэлгийн орох хэсэг болон тасаг нэгжид 22 тэргэнцэр байршуулсан 	
1.5.4	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр санаачлагатай ажиллаж, түрээсийн орон сууц, бусад хэлбэрээр орон сууцтай болгох үйл ажиллагааг дэмжиж ажиллана	-	Орон сууцны дэмжлэг авсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	11 эмнэлгийн мэргэжилтнийг амьдрах байраар хангагдсан	10-аас доошгүй эмнэлгийн мэргэжилтнийг амьдрах байраар хангана.	<ul style="list-style-type: none"> Орон нутагт ирж ажиллах эмнэлгийн мэргэжилтнийг амьдрах байраар ханган, Бүрэгхангай, Тэшиг сумын захиргаанаас 1 их эмч, 1 сувилагчид амьдрах байр, байшин шинээр барьж өгч, Хутаг-Өндөр, Сайхан сум, Хялганат тосгонд баригдсан төрийн албан хаагчийн орон сууцанд 4 их эмч, 1 сувилагч амьдарч байна. Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Орхон сумын эрүүл мэндийн төв болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн Халдварт сүрьеэгийн тасгийн хуучин барилгад 15 ажилтныг амьдрах байраар хангасан. 	100
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
2.1.1	Төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийх (Халдвар судлал, хүүхдийн эрүүл ахуй, хүнсний үйл ажиллагаа, амралт, аялал жуулчлал, зочид буудлын объектуудад)	Улсын төсөв	Хэрэгжилтийн хувь	50-70 хувь	80 хувь болгож нэмэгдүүлнэ.	Эрүүл мэндийн сайдын “Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай” А/484 дугаар тушаалын хавсралтад заагдсан 36 объектыг төлөвлөгөөт хяналт шалгалтад 100 хувь хамруулсан. 12 төрлийн хяналтын хуудсаар үнэлгээ хийснээс дунд эрсдэлтэй 22, бага эрсдэлтэй 14 объект үнэлэгдэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 427 заалт бүхий 33 албан шаардлагыг хүргүүлсэн. Албан шаардлагын хэрэгжилт 12 сарын 10-ны байдлаар 75.5 хувьтай байна. Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар 17 объектын эрсдэлийг дундаас бага руу бууруулсан үр дүнтэй байна.	100

2.1.2	Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг цаг тухай бүр шуурхай зохион байгуулах	Улсын төсөв	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	-	90 хувьд хүргэнэ.	Удирдах дээд байгууллагаас төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамж болон байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс өргөдөл гомдол ирээгүй тул төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдээгүй болно.	100
Гурав.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
3.1.1	Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх	-	Донорын тоо Цус цусан бүтээгдэхүүний хангамж, нөөцийн хувь	Донорын тоо-1020 Цус цусан бүтээгдэхүүний хангамж, нөөцийн хувь-100%	Донорын тоо-1050 Цус цусан бүтээгдэхүүний хангамж, нөөцийн хувь-100%	<ul style="list-style-type: none"> Нийт Эрүүл мэндийн байгууллагуудад цусны аюулгүй байдлыг ханган ажиллах, эмнэлзүйн сайн дадал, цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээг хэвшүүлэх, цус сэлбэх үйл ажиллагааг зөв зохион байгуулах, цус, цусан бүтээгдэхүүний хангамж, нөөц, тээвэрлэлт зэрэг сэдвээр сургалтуудыг танхим болон цахимаар зохион байгуулж, 140 эмч, эмнэлгийн мэргэжилтэнийг хамруулсан. Аймгийн хэмжээнд цусны донор зохион байгуулалт, донор хадгалалт, урамшуулал, алдаршуулалт, шинэ донор элсүүлэх зэрэг үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулан, донорын тоо зорилтод түвшинд хүрч, цус, цусан бүтээгдэхүүний хангамж, нөөц 100 хувьтай ажиллаж байна. Аймгийн цусны салбар төв Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс зохион байгуулсан цахим дэмжлэгт хяналт, үнэлгээнд амжилттай хамрагдсан. 	100
3.1.2	Салбарын хэмжээнд санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулах	-	Санхүүгийн зөрчилгүй дүгнэлттэй байгууллагын тоо	Санхүүгийн зөрчилгүй дүгнэлттэй байгууллагын тоо-11	Санхүүгийн зөрчилгүй дүгнэлттэй байгууллагын тоо-13	Эрүүл мэндийн байгууллагуудын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлтээр нийт 18 байгууллага “Өөрчлөлтгүй” буюу зөрчилгүй санал дүгнэлт хүлээн авсан байна.	100
Дөрөв.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
4.1.1	Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, програм хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, тасралтгүй байдлыг хангана.	-	Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, програм хангамжийн дэд бүтцийг хөгжүүлсэн байх	Интернэтийн хурдыг 5мб-ээр нэмэгдүүлсэн. 40.1 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн 20 компьютер болон дагалдах	Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, програм хангамжийг сайжруулсан байна.	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн байгууллагуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Dell брэндийн 71ш, Асег брэндийн 3ш суурин компьютер, 103 зөөврийн компьютер нийлүүлэгдсэн. Мөн байгууллагын урсгал зардлаар 4 ЭМБ-ууд 11ш зөөврийн компьютероор хангагдсан. 	100

				хэрэгслээр хангасан.		<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн мэдээллийг иргэний баталгаажилтаар эрүүл мэндийн байгууллага хооронд дамжуулах системийг Нэгдсэн эмнэлэг E-Health, Баяннуур, Хялганат ЭМТ 2024 оноос Wings, бусад анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд Health.gov.mn програмуудыг ашиглаж байна. Иргэд хөнгөлөлтэй болон энгийн эмийн жорийн мэдээллийг https://e-mongolia.mn/ - системээс авах боломжтой болсон. 	
4.1.2	Эмч, эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, ажилтнуудын хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтанд хамруулах	-	Сургалтанд хамрагдсан албан хаагчдын эзлэх хувь	Хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтанд нийгмийн салбарын албан хаагчдын 50 хувийг хамруулсан байна.	Хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтанд нийгмийн салбарын албан хаагчдын 90 хувийг хамруулсан байна.	<ul style="list-style-type: none"> Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, ГХБХБГ, БОАЖГ, ГБХХГ болон ахмад хуульчдын хамтарсан багаас зохион байгуулсан “Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээ” сургалтад Эрүүл мэндийн байгууллагуудын төрийн албан хаагчид идэвхтэй хамрагдаж хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэлтэй болсон. ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дарга С.Амар аймгийн НЭ-ийн 50 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулиар сургалт зохион байгуулсан. 	100
4.1.3	Эрүүл мэндийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах сургалтанд хамруулах	-	Сургалтанд хамрагдсан албан хаагчдын эзлэх хувь	Ёс зүй, харилцаа, хандлагын сургалтанд нийгмийн салбарын албан хаагчдын 50 хувийг хамруулсан байна.	Ёс зүй, харилцаа, хандлагын сургалтанд нийгмийн салбарын албан хаагчдын 90 хувийг хамруулсан байна.	<ul style="list-style-type: none"> Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн зөвлөх эмч Анагаах ухааны доктор, профессор Т.Ганцэцэг, сургалтын мэргэжилтэн Э.Мягмарцэрэн нартай хамтран “Эрүүл мэндийн ажилтын сэтгэл зүй”, АШУУИС-ийн Эрдмийн сургуулийн Анагаах ухааны эрх зүй, боловсрол судлалын тэнхимийн багш, хуульч өмгөөлөгч Э.Ганбаттай хамтран “Мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлага”, “Амьдралд суурилж, суралцахуй” ТББ, АШУУИС-ийн багш Анагаах ухааны доктор, профессор С.Наранчимэг, Сувилахуйн ухааны докторант С.Нармандах нартай хамтран “Мэргэжлийн ёс зүй, харилцааны ур чадвар” сургалтуудыг зохион байгууллаа. 	100

						<ul style="list-style-type: none"> Сургалтад Эрүүл мэндийн байгууллагуудаас 300 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, хууль эрх зүй, ёс зүйн чиглэлээр зохих мэдлэг, мэдээлэлтэй болсон. 	
5.Хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
5.1.Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ							
5.1.1	Аймгийн удирдах ажилтны шуурхай хуралд оролцож, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг байгууллагын дарга нарт мэдээлэх	-	Зохион байгуулсан хурлын ирцийн бүртгэлээр	2023 онд Удирдах ажилтны шуурхай хурал 25 удаа хуралдаж, цаг үеийн шинжтэй 68 мэдээ мэдээллийг хүргэсэн	Удирдах ажилтны шуурхай хуралд 24 удаа оролцож, цаг үеийн шинжтэй 5 мэдээ, мэдээллийг байгууллагуудад хүргэсэн байна	<ul style="list-style-type: none"> Аймгийн удирдах ажилтны шуурхай хуралд оролцож, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг 10 удаа байгууллагын дарга нарт мэдээлсэн. Харьяа Эрүүл мэндийн байгууллагуудтай 16 удаа цахимаар холбогдож, цаг үеийн тулгамдсан асуудлаар мэдээлэл солилцож, 442 албан хаагч оролцсон байна. 	100
5.1.2	Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжиж хамтран ажиллах	Өөрийн хөрөнгө	Ажил, арга хэмжээний тоо	120 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж давхардсан тоогоор 150 гаруй ажил, арга хэмжээг зохион байгуулсан	5 төрийн бус байгууллагатай хамтран ажилласан байна	<ul style="list-style-type: none"> Салбар дундын хамтын ажиллагааг сайжруулан ажиллаж, төр, иргэний нийгмийн хамтын ажилгааны хүрээнд “Булган манлайлал”, “Оргил мээж холбоо”, “ЭРТЭЧ ЭЭЖҮҮД” клуб, ахмадын “ЖИГҮҮР 1 , 2” хамтлаг, Сайхан монгол телевиз, МУЗН болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Төрийн болон ТББ, иргэдийн дунд уулзалт, ярилцлага хэлэлцүүлэгийг 2 удаа зохион байгуулан, 4 асуудлыг хэлэлцүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 90.6 хувьтай байна. Сайхан монгол телевиз, МУЗН-тэй хамтран “Олон нийттэй харилцах, ил тод байдлыг хангахад сайн дурын идэвхтнүүдийн оролцоо”, “Эрсдэлийн харилцаа холбоо, сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэх сургагч багш бэлтгэх” сургалтад 5 сургагч багшийг бэлтгэсэн. “Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо”-ноос зохион байгуулсан 12 удаагийн цахим сургалтад олон нийтийн эрүүл мэндийн ажилтан, сүрьеэ, 	100

						<p>статистикч, лаборант зэрэг эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан.</p> <ul style="list-style-type: none"> • “Эм холбоо” ТББ нь 38 эмийн сан, 22 эм зүйч, 37 эм найруулагч, 28 туслах ажилчдын бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулдаг. Энэ онд Эрүүл мэндийн газартай хамтран “Эм, эмнэлгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга”, “Цахим жорын хэрэгжилт”, “Эмийн зохистой хэрэглээ”, “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх дэлхийн 7 хоног” зэрэг сэдэвт танхимын сургалтыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 315 эмч, эмнэлгийн болон эмийн мэргэжилтэнүүдийг хамруулсан байна. 	
5.1.3	Төрийн албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэн, чадваржуулах	Өөрийн хөрөнгө	Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	Мэргэшүүлэх багц сургалтад 47, 5 албан хаагч магистр, зэргийн нэмэгдүүлэх 3 албан хаагчдыг хамруулсан байна.	Сургалт нийгмийн баталгааны хөтөлбөрт хөрөнгө тусгаж 1-2 албан хаагч сургасан байна. (Төрийн албанд анх томилогдсон болон дунд хугацааны давтан сургалт, ахлах, эрхлэсэн, архив бичиг хэргийн зэрэг нэмэгдүүлэх, мэргэшсэн нягтлан бодогч, магистр, доктор ... гэх мэт)	<ul style="list-style-type: none"> • Төрийн албан хаагчдын давтан мэргэшүүлэх багц цагийн сургалтад 320 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, Нийгмийн эрүүл мэндийн магистрийн зэрэг горилох сургалтад 2 мэргэжилтэн суралцаж байна. • Төрийн албанд анх томилогдсон сургалтад 2, дунд хугацааны давтан сургалтад 1 төрийн захиргааны албан хаагч хамрагдсан. • Эрүүл мэндийн газар, Хишиг-Өндөр, Хялганат, Бүрэгхангай сумын ЭМТ-ийн бичиг хэргийн ажилтнууд давтан мэргэших сургалтад хамрагдсан. • Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтад албан хаагчид тогтмол хамрагдаж байна. • Төгсөлтийн дараах үндсэн мэргэжил олгох сургалтад 4 их эмч, төрөлжсөн мэргэшил олгох сургалтад 3 их эмч, 4 сувилагч, мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан. 	100
5.1.4	Байгууллагын сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Өөрийн хөрөнгө	Сургалт, нийгмийн баталгааны хэрэгжүүлсэн хувь	2023 онд төрийн байгууллагууд 3251 албан хаагчийг нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2,582,915,441.00	80%-аас дээш хувь	<ul style="list-style-type: none"> • Сургалт, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг 3 чиглэлээр боловсруулан ажилласан. • Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн байгууллагуудын давхардсан тоогоор 1400 эмнэлгийн мэргэжилтэн ажлын байрны давтан 	100

				<p>төгрөгийг зарцуулсан байна.</p>	<p>мэргэшүүлэх сургалтад, 15 мэргэжилтэн гадаад сургалтад хамрагдсан.</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн байгууллагууд ажилтнуудынхаа амрах өрөөг тохижуулах, хувцасны шкафыг шинэчлэх ажлын өрөөний тохижилтод 7.3 сая төгрөг зарцуулж, 15 Эрүүл мэндийн байгууллага 511 ажилтанд 72.3 сая төгрөг эрүүл ахуйн шаардлага хангасан нэгдсэн загвартай ажлын хувцас, дулаан хувцсаар хангасан байна. • Салбарын ажилтнуудын 77.5%-ийг Нэгдсэн эмнэлэг болон лавлагаа шатлалын эмнэлгүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, өвчтэй илэрсэн 104 ажилтныг хэвтүүлэн эмчилж, 122 албан хаагчдыг өдрийн эмчилгээ болон сэргээн засах эмчилгээнд хамруулж, нийт Эрүүл мэндийн байгууллагууд 12.2 сая төгрөг зарцуулсан. • В вирусын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан 377 ажилтныг дархлал тогтоцын шинжилгээнд хамруулж, дархлалын тогтоц буурсан, шинээр ажилд орсон 107 ажилтныг В вирусын эсрэг дархлаажуулалтад хамруулсан. • Орон нутагт ажиллах их эмч, сувилагч бэлтгэх ажлыг орон нутгийн засаг захиргааны байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулж, 4 их эмч, 1 сувилагч, 1 бага эмчийн сургалтын төлбөрт 17.7 сая төгрөг зарцуулсан. • Орон нутагт ирж ажиллах эмнэлгийн мэргэжилтнийг амьдрах байраар ханган, Бүрэгхангай, Тэшиг сумын захиргаанаас 1 их эмч, 1 сувилагчид амьдрах байр, байшин шинээр барьж өгч, Хутаг-Өндөр, Сайхан сум, Хялганат тосгонд баригдсан төрийн албан хаагчийн орон сууцанд 4 их эмч, 1 сувилагч амьдарч байна. • Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Орхон сумын эрүүл мэндийн төв болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн Халдварт сүрьеэгийн тасгийн хуучин барилгад 15 ажилтныг амьдрах байраар хангасан.
--	--	--	--	------------------------------------	--

						<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн байгууллагууд “Хөдөлмөрийн дотоод журам” болон холбогдох журмаар байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж, 69.6 сая төгрөг зарцуулжээ. 	
5.1.5	Гадаад албан ажлаар, төрийн зардлаар ажиллах Төрийн албан хаагчид хуулийн хугацаанд аймгаас зөвшөөрөл авах, ирсэн даруйд 5 хоногт багтаан илтгэх тайлангаа ирүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	-	100 хувь	ЭМЯ, ЭМХТ, АЗДТГ-аас зохион байгуулж буй гадаад сургалтад хамрагдаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн сургалтын хугацаа дуусч тайлан мэдээллийг ЭМХТ, ЭМЯ-нд тухай бүр хүргүүлсэн.	100
5.1.6	Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх хэрэглэх, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, зарцуулах журмын хэрэгжилтийг хангуулах.	Өөрийн хөрөнгө	Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан журмын мэдээ, тайлангаар	Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байсан	Хэвлэмэл хуудасны зарцуулалтын тайлан мэдээг хагас бүтэн жилээр тайлагнаж хэвшсэн байна.	<ul style="list-style-type: none"> Байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллах тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх хэрэглэх, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, зарцуулах журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар хэвлэлийн компаниар байгууллагын даргын тушаал 550, А5 хэвлэмэл хуудас 300, А4 хэвлэмэл хуудас 200, хяналтын улсын байцаагчийн акт, дүгнэлт, танилцуулгын хэвлэмэл хуудас 220 ширхэгийг тус тус хэвлүүлсэн. А5 хэвлэмэл хуудас 87, тушаалын хэвлэмэл хуудас 120, А4 хэвлэмэл хуудас 40ш, улсын байцаагчийн хэвлэмэл хуудас 57 ширхэг үлдэгдэлтэй байна. Хэвлэмэл хуудасны зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гарган, холбогдох байгууллагад тайлагнасан. Байгууллагын тамгыг шинэчилсэн. 	100
5.1.7	Сум байгууллагууд Монгол бичгийн хэвлэмэл хуудсаа хэвлүүлж, хэрэглэж хэвших, Монгол бичгийн хэвлэмэл хуудас дээр албан бичгээ монгол бичгээр сийрүүлж, компьютерт шивж сурах.	Өөрийн хөрөнгө	Сум байгууллагын хэвлэмэл хуудас түүн дээр монгол бичгээр сийрүүлж байгаа тоогоор	Аймгийн хэмжээгээр Монгол бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж хэвшээгүй.	Сум байгууллагуудын албан хаагчдын Монгол бичгийн мэдлэг сайжирч, компьютерт шивж сурсан байна.	<ul style="list-style-type: none"> Байгууллагын албан хаагчдын компьютерт монгол бичгийн фонт суулган, монгол бичгээр шивж сурч байна. Удирдлагын академиас төрийн албан хаагчдад зориулсан “Монгол бичиг”-ийн цахим сургалтын линкийг ЭМБ-уудад хүргүүлсэн. “Монгол бичиг”-ийн цахим сургалтад 20 албан хаагч хамрагдсан. 	90

						<ul style="list-style-type: none"> Байгууллагын төрийн албан хаагчдын өрөө тасалгааны хаяг, хувийн хэргийн хавтасны хаяг зэргийг монгол бичгээр үйлдсэн. 	
5.1.8	Сум, байгууллагуудын албан хаагчдад “Баримт бичиг зохион бүрдүүлэх арга зүй, баримт бичгийн стандарт”-аар Архивын ерөнхий газраас мэргэжилтэн урьж сургалт зохион байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө авах.	Өөрийн хөрөнгө	Сум, байгууллагын албан хаагчдын сургалтад хамрагдсан ирцийн тоогоор	Албан хаагчдын мэдлэг дундаж, мэргэжил арга зүй зөвлөгөө дутмаг байсан.	Албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн мэдлэг чадвар эзэмшсэн байна.	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн газар, Хишиг-Өндөр, Хялганат, Бүрэгхангай сумын ЭМТ-ийн бичиг хэргийн ажилтнууд архив, албан хэрэг хөтлөлтийн давтан мэргэших сургалтад хамрагдсан. Эрүүл мэндийн байгууллагын архив, бичгийн хэргийн ажил хариуцсан 15 ажилтан албан хэрэг хөтлөлт, архивын ажилтны мэргэжлийн цахим сургалтад хамрагдсан. Орхон, Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төвд шинээр ажилд орсон ажилтан ЭМГ-т 5 хоногийн ажлын байрны сургалтад хамрагдсан. 	100
5.1.9	“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн дагуу сум албан ёсны вэб сайттай болох, шаардлагатай мэдээллийг хугацаандаа байршуулсан байх	Өөрийн хөрөнгө	Байгууллагын вэб сайт хөтлөлтийн хувь	23 агентлаг вэб сайттай, өргөдөл гомдлын цэс үүсгэсэн 50 хувь	Агентлагийн вэб сайтыг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн дагуу засварлаж, шинэчилж 46 төрлийн мэдээ мэдээллийг хугацаандаа 100 хувь байршуулах.	<ul style="list-style-type: none"> Байгууллагын вэб сайтад өдөр бүр мэдээ мэдээллийг ил тод нээлттэй байршуулан ажиллаж, 12 сарын 10-ны байдлаар 36784 удаагийн хандалттай байна. Шил ажиллагааны /www.shilen.gov.mn/ системд <ol style="list-style-type: none"> Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийн ил тод, нээлттэй байдал Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал гэсэн 5 бүлгийн 87 мэдээллийг оруулж илгээсэн байна. Төсөв санхүүгийн мэдээллийг байгууллагын “Ил тод байдал”-ын самбарт болон Шилэн дансанд тухай бүр шинэчлэн байршуулсан. 	100

						<ul style="list-style-type: none"> Shilen.gov.mn сайтад мэдээллийг хугацаанд нь байршуулж, 99.0%-тай үнэлэгдлээ. 	
5.1.10	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, саналыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, хэрэгжилтийг улирал тутам тайлагнах	Өөрийн хөрөнгө	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, саналын шийдвэрлэлтийн хувь Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланг хугацаандаа үнэн зөв ирүүлсэн сумын тоо	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 80%, шийдвэрлэлтийн тайланг 100% хугацаандаа ирүүлсэн.	Бичгээр болон цахимаар хүлээн авсан өргөдөл гомдлыг 100% шийдвэрлэн, тайлангаа хугацаандаа ирүүлсэн байх	<ul style="list-style-type: none"> 2024 оны эхний 12 сарын 11-ны байдлаар иргэдээс 202, байгууллагын албан хаагчдаас 30 нийт 232 өргөдөл ирснийг хүлээн авч бүртгэн, хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. Нийт 232 өргөдөл хүлээн авснаас 3 өргөдөл хугацаа болоогүй, өргөдөлг гомдлын шийдвэрлэлт 98.7% хувьтай байна. Нийт өргөдлийн <ul style="list-style-type: none"> - Албан бичиг болон цаасаар-229 - Байгууллагын утсаар-3 ирсэн байна. <p>Үүнээс:</p> <p>Санал, гомдол - 10 /4.3%/</p> <p>Хүсэлт –222 /95.7%/</p> <ul style="list-style-type: none"> Нийт 232 өргөдлийг агуулгаар нь ангилбал: <ul style="list-style-type: none"> - Гэрчилгээ авах хүсэлт ирүүлсэн 3 /1,3%/ - Ажилд орох хүсэлт 23 /9,9%/ - Суралцах хүсэлт ирүүлсэн 9 /3,9%/ - Тэтгэмж хүссэн тухай хүсэлт 143 /61,6%/ - Бусад-44 /хүсэлт гаргах, материал хүргүүлэх 18,9%/ - Гомдол гаргасан 10 /4,4%/ /утсаар-3, бичгээр-7/ өргөдөл хүлээн авсан байна. Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, улирал бүр мэдээг гарган аймгийн ЗДТГ-ын ХМОНХА-нд хүргүүлэн ажилласан. 	100
5.1.11	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системийг бүрэн нэвтрүүлж албан хаагчдыг хамруулах	Өөрийн хөрөнгө	ERP системд холбогдсон цахим хаяг хэрэглэгч TAX-ын хувь	Нийт TAX-аас 30% нь ERP-системд холбогдсон байна.	Байгууллагын албан хаагчдын 100-аас доошгүй хувь ERP системд холбогдож цахим хаягийг хэрэглэж хэвшүүлсэн байна	Эрүүл мэндийн газрын 23, Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 46 алба хаагч төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн https://erp.e-mongolia.mn/ системд холбогдон, албан ажилдаа хэрэглэж хэвшсэн байна.	100

5.1.12	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, сум /гэрээ/, байгууллагын /гүйцэтгэлийн төлөвлөгөө/ гэрээний хэрэгжилтүүдийг заасан хугацаанд чанартай тайлагнах	-	Хугацаа хоцроолгүй тайлагнасан байдал Хэрэгжилтийн хувь	14 сум, 20 агентлаг заасан хугацаанд тайлан мэдээг ирүүлж, 3 сум, 4 агентлаг хугацаа хоцроож тайлагнасан	Тайлан мэдээг заасан хугацаанд тайлагнасан байна	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг цахим системээр тухай бүр хугацаанд нь тайлагнасан.	100
5.2.Хууль, эрх зүйн хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ							
5.2.1	Төрийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт амжилттай хамрагдах	Өөрийн хөрөнгө	Улсын үзлэгийн шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэх	Шалгуур үзүүлэлтийг 2019 онд 80-90 хувиар хангасан	Шалгуур үзүүлэлтийг 95 хувиас доошгүй хувиар хангах	<ul style="list-style-type: none"> Архивын улсын үзлэг хийгдэх ажлын дагуу бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж, байгууллагын архивын дотоод тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Улсын үзлэгийн 4 төрлийн шалгуур үзүүлэлт тус бүрээр өөрийн үнэлгээг гаргаж үзлэгт бэлтгэх ажлыг бүрэн зохион байгуулсан. 	100
5.2.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын зохион байгуулах, хяналт тавих, БНШК байгуулж, ажиллуулах, байгууллагын архивын баримтын тооллого хийх, хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг гаргаж хэрэгжүүлэх	Өөрийн хөрөнгө	Зохион байгуулсан сургалт, хяналт шалгалтын тоо, баримт нягтлан шалгах комиссын хурал, тооллогын үр дүн	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн заавар, стандарт, байгууллагын архивын заавар, тооллогын журам шинээр батлагдсан	Хууль, заавар, дүрэм, стандартын хэрэгжилтийг 95 хувьд хүргэх	<ul style="list-style-type: none"> ЭМГ-ын хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг шинээр гарган, байгууллагын архивын баримтын тооллого хийсэн. Аймгийн Төрийн архивтай хамтран архивт хадгалагдаж байгаа материалуудын тооллогыг хийж гүйцэтгэсэн. 	100
5.2.3	"Бүх нийтийн эрх зүйн боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрх зүйн сургалт сурталчилгааг дотооддоо буюу өөрийн ажилтнуудад болон гадагш чиглэсэн хэлбэрээр зохион байгуулах, аймгийн хэмжээнд нэгдсэн	Өөрийн хөрөнгө	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Өмнөх онд эрх зүйн сургалт сурталчилгаа хэдэн удаа зохион байгуулсан, хэдэн хүн оролцсон нь тодорхой бус байсан	Жилдээ 2 чиглэл тус бүрээр 2-с доошгүй удаа зохион байгуулсан байх Хэдэн удаа, ямар сэдвээр, хэдэн хүн оролцсон нь тодорхой болж	<ul style="list-style-type: none"> "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Байгууллагын цахим хуудсаар хууль эрх зүйн зөвлөгөө мэдээллийг иргэдэд тогтмол хүргэн ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарын төрийн алба хаагчдад хууль эрх зүйн мэдлэг олгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн чиглэлээр аймгийн ЗДТГ, 	100

	байдлаар зохион байгуулагдах сургалт семинарт оролцох				тайланд тусгагдсан байна.	Цагдаагийн газар болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран танхимаар 5 удаа “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, Мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлага” зэрэг сэдвээр сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 350 гаран албан хаагчийг хамруулсан байна.	
5.2.4	"Зөв дадал-Архигүй орчин" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллага дээрээ судалгаа гаргаж, сургалт зохион байгуулж, хяналт тавих	Өөрийн хөрөнгө	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Байгууллагын хэмжээнд уг хөтөлбөрт хэрхэн хамрагдаж байгаа нь тодорхойгүй байсан	Байгууллагын хэмжээнд архидан согтуурах, явдал гаргахгүй байх	<ul style="list-style-type: none"> Аймгийн Засаг даргын А/32 дугаар захирамжааар “Архи тамхи-Шинэ үеийн сонголт биш” нэрэмжит сарын аяныг жил бүрийн 3-р сард Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшээд байна. ЕБС-ийн 8-11-р ангийн 186 сурагчдад 2 төрлийн сэдвээр сургалт, мэдээллийг зохион байгуулж, 2 төрлийн санамжийг 500 ширхэгийг хэвлэн тараасан. Мөн Хутаг-Өндөр сумын дотуур байрны 54 хүүхдэд “Архины хор хөнөөл”-ийн талаар сургалтыг зохион байгуулсан. ЭМЯ, НЭМҮТ-өөс гаргаж байгаа 8 нэр төрлийн постор, шторк, мэдээлэлийг Эрүүл мэндийн газар, ЭМБ-уудын цахим хуудсанд байршуулан 2086 иргэнд хүрсэн. Архи, тамхи, дам тамхидалт, дотоод орчны бохирдлын талаар Эрүүл мэндийн байгууллагуудад цахимаар сургалт зохион байгуулж мэргэжил арга зүйгээр хангасан. Дээрх ажлын хүрээнд Эрүүл мэндийн байгууллагууд харьяа орон нутгийн албан байгууллага, олон нийтэд цаасан болон цахим хэлбэрээр зөвлөмж мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэн давхардсан тоогоор 2137 хүн хамрагдсан. 2024 онд 54 иргэн архины эмчилгээнд хамрагдаж урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх нийгэмшүүлэх болон харшил үүсгэх эмчилгээ болон ганцаарчилсан, бүлгийн сэтгэл засал эмчилгээ зэрэг тусламж, үйлчилгээг үзүүлсэн байна. 	90

						<ul style="list-style-type: none"> • “Архи тамхи шинэ үеийн сонголт биш” уриан дор зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж, 4 төрлийн постер бэлтгэн 338 иргэнд цаасан болон цахим хэлбэрээр хүргэсэн. • Архи тамхины хор уршгийг таниулах зорилгоор сургалтыг зохион байгуулах, зөвлөмж мэдээлэл түгээх ажлуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 733 иргэн хамрагдсан. 	
5.2.5	УИХ-ын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжилтийг байгууллагынхаа хэмжээнд зохион байгуулж, тайлагнах.	Өөрийн хөрөнгө	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Шинээр батлагдсан хөтөлбөр	Хөтөлбөрт тусгагдсан ажлаас өөрийн байгууллагад хамаарах ажил, арга хэмжээг зохион байгуулах.	<ul style="list-style-type: none"> • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг танилцуулах сургалтын сургалтын төлөвлөгөөг батлуулан байгууллагын цахим вэб хуудсанд ил тод нээлттэй байршуулан, төрийн албан хаагчдад 3 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан. Сургалтын гарын авлага, хичээлийг нийт ЭМБ-уудад хүргүүлсэн. • АТГ-аас орон нутагт зохион байгуулсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилго, зорилт, үйл ажиллагааг танилцуулж, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүн, анхаарах асуудлын талаар зохион байгуулсан сургалтад ХАСХОМ мэдүүлдэг төрийн албан хаагчид хамрагдсан. 	100
5.2.6	Нийтийн албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулах, хадгалах, хяналт тавих, Нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянуулах	-	ХАСУМ-ийг тухай бүр хянуулсан алба хаагчийн тоо, хувь	Холбогдох агентлагаас бусад агентлагийн мэдүүлэг гаргагч нарын бүртгэл судалгаагүй байсан.	ХАСХОМ болон ХАСУМ-тэй холбоотой бүртгэл судалгаатай болж, зөрчил дутагдал гаргаагүй байх.	<ul style="list-style-type: none"> • 2023 оны ХАСХОМ мэдүүлгийн 29 албан тушаалтан, 2024 онд нийтийн албанд нэр дэвшин ХАСУМ мэдүүлгийг 10 албан тушаалтан, 2024 оны ХАСХОМ мэдүүлгийг 9 албан тушаалтан тухай бүр хуулийн хугацаанд гаргасан байна. • Оны эхний 11 сарын байдлаар ХАСУМ болон ХАСХОМ мэдүүлгийн зөрчил, дутагдал гараагүй. 	100
5.2.7	Байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтыг сайжруулах, зорилгоор гэрэлтүүлэг, камерын тоо байршлыг нэмэгдүүлэх	Өөрийн хөрөнгө	Нэмэгдсэн гэрэлтүүлэг, камерийн тоо, дотоод хяналтын ажлын хэсгийн төлөвлөгөө	Байгууллага агентлагын ажлын байранд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, тэдгээрийн ажилтны	Нэгдсэн судалгаа, тоо баримт дээр үндэслэн урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах	Байгууллагын хэмжээнд гадна, дотно орчинд нийт 6 камер, 4 гэрэлтүүлэг ажиллаж, дотоод хяналтыг сайжруулан ажиллаж байна.	100

				үйлдсэн гэмт хэрэг зөрчлийн судалгаа байхгүй	боломжтой болно.		
5.3.Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ							
5.3.1	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Бүх нийтээр мод бут тарих ажилд зохион байгуулалттайгаар оролцох	-	Булган сумын ЗДТГ-аас хуваарилсан тооны мод тарьж, арчлан ургуулна.	Аймгийн хэмжээнд ногоон байгууламж, айл өрхүүд 137270 ширхэг мод, бут, ойжуулалт нөхөн сэргээлтийн чиглэлээр 533810 ширхэг мод, цөлжилт газрын доройтлыг бууруулах зорилгоор хамгаалалтын зурвас, ойн зурвасын ажилд 24585 ширхэг мод тарьж нийт аймгийн хэмжээнд 700665 ширхэг мод таригдаад байна.	Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн байх	<ul style="list-style-type: none"> • "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Бүх нийтээр мод бут тарих арга хэмжээнд нэгдэн, хавар, намрын тариалалтад 3 төрлийн 125 мод тарьж тарьж, өмнөх жилийн тарьсан модоо усалж арчилгаа тордолт хийсэн. • 5 ажилтан өөрийн эзэмшлийн хашаандаа 200 гаруй мод бут сөөгийг тарималжуулсан. 	100
5.3.2	"Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аянд идэвхитэй оролцож, бүх нийтийн цэвэрлэгээнд оролцох (зам дагуу хог цэвэрлэгээний ажил, орчны 50 метрийн хог хаягдал, хог ургамал, цас мөсийг арилгах)	-	Зохион байгуулсан нийтийн цэвэрлэгээний ажилд идэвхитэй оролцоно.	Аймгийн хэмжээнд 805982.5 га газрын 27425.3 тн, 148 гол горхи, уст цэгийн 4263.3 тн хог хаягдлыг цэвэрлэн хогийн төвлөрсөн цэгт хүргэж, үхсэн малын 21527 сэг зэм, 1720 нохой, 126 муур устган энэ ажилд	Хотын өнгө үзэмжийг сайжруулж, тав тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> • Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяны хүрээнд Хөвсгөл-Булган-Эрдэнэт чиглэлийн хот хоорондын 85км улсын чанартай авто замын хавар, зуны улирлын цэвэрлэгээгээр хуваарьт 2 км газрын хог хаягдлыг цэвэрлэсэн. • Байгууллагууд өөрийн орчны цас хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хэвшсэн. Шарилж устгал, тайралт таналтыг улсын баяр наадам, Олон улсын Алтаргана наадамд бэлтгэн 2 удаа бүх нийтээр зохион байгуулсан. 	100

				давхардсан тоогоор 406 аж ахуйн нэгж, байгууллага, 7980 хүн, 373 автомашин техник оролцлоо.			
5.3.3	Байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээнд хэмжих хэрэгсэл суурилуулах	Байгууллагын төсөв	Дулааны тоолуурын заалтаар төлбөр төлөх	Дулааны тоолуур байхгүй	Дулааны тоолуур суурилуулсан байна.	Байгууллагад дулааны эрчим хүчний тоолуур суурилагдсан бөгөөд тоолуурын заалтаар төлбөр хийгдэж байна.	100
5.3.4	Эрчим хүчний хэрэглээг бууруулах, хэмнэлт гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг гаргах	Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөгүй	Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Эрчим хүчний хэрэглээг бууруулах, хэмнэлттэй ажиллах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
5.3.5	"Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Бүсийн зорилтот хөтөлбөр"-ийн төсөлд санал ирүүлэх	-	Заасан хугацаанд ирүүлэх	Санал авч байна	Санал ирүүлээд аймгийн ИТХ-аар танилцуулагдан ЭЗХЯ-д хүргэгдсэн байх	"Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Бүсийн зорилтот хөтөлбөр"-ийн төсөлд тухай бүрд нь санал хүргүүлсэн.	100
5.4. Нийгмийн бодлогын хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ							
5.4.1	Хүн бүр эх хэл, соёлоо дээдэлж зөв бичиж хэрэглэж хэвших, байгууллага, хамт олон "Бүх нийтээрээ хос бичигтэн" болоход уриалсан нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах, сургалтад хамрагдах	-	Байгууллагын хаяг, цахим сайт, бичиг хэргийн хөтлөлтийг уйгаржин бичгээр бичиж хэвших, байгууллагын албан хаагчдын монгол хэл, бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Албан хаагчдын 40-50 хувь хамрагдсан.	Үндэсний бичиг 3 хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь Албан хаагчдыг 100 хувь хамруулах	<ul style="list-style-type: none"> "Стандарт хэмжил зүйн газрын "Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS 6395:2022 баримтлан А4, А5 албан бичиг, захирамжлалын баримт бичгийн хэвлэмэл хуудасны бүрдлийг кирилл, монгол бичгээр хэвлэсэн. Байгууллагын албан хаагчдаас "Монгол бичиг"-ийн ахицын шалгалтыг авч, дүгнэсэн. Байгууллагын төрийн албан хаагчдын өрөө тасалгааны хаяг, хувийн хэргийн хавтасны хаяг зэргийг монгол бичгээр үйлдсэн. Албан хаагчдаас "Монгол бичиг"-ийн ахицын шалгалтыг авч, дүгнэхэд дунд шатны 	90

						албан хаагчдын унших чадварын гүйцэтгэлийн дундаж 80.3%-д хүрч 40.4%-иар нэмэгдсэн, зөв бичих чадварын түвшин 93.5% хүрч 2021 оны буюу гарааны түвшингээс 55.2%-иар дээшилсэн байна. Анхан шатны суралцагчдын унших чадварын гүйцэтгэл 57.6% буюу 2021 оны гарааны түвшингээс 25.2%-иар нэмэгдэж, бичих чадварын түвшин 50.3% буюу гарааны түвшингээс 30.2%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	
5.4.2	“Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох, сорил”-д байгууллагын албан хаагчдыг хамруулах	-	Байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулах	Албан хаагчдын 30-35 хувь хамрагдсан.	Албан хаагчдын 70 хувийг хамруулах	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 053 тоот зарлиг, “Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг байгууллагын 22 албан хаагчдаас “Бие бялдарын сорил”-ыг 18-64 насны ангиллаар авч программд шивж цахимд байршуулсан. Сорилын дүнгээр А үнэлгээтэй 7, В үнэлгээтэй 10, С үнэлгээтэй 5 албан хаагч үнэлэгдэж, В, С үнэлгээтэй албан хаагчдад цаашид дасгал хөдөлгөөн хийх, тэнцвэртэй хооллох талаар зөвлөгөө өгсөн. Байгууллагын 25 албан хаагчаас идэвхтэй хөдөлгөөний чиглэлээр судалгаа авч, нэгтгэн дүгнэхэд өдөр тутмын амьдралын хэв маягтаа дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэхийг чухалчилж, дасгал хөдөлгөөн хийхийг хоол идэх, унтах, ажилдаа явах, компьютерийнхээ ард суух зэрэг өдөр тутмын дадал, зуршил мэт болгосон 11 албан хаагч байсан. 14 албан хаагч бие махбодын эрүүл мэнд, ялангуяа зүрх судасны өвчнөө даван туулах гэж, эсвэл жингээ хасах, булчингийн массаа томруулахын тулд дасгал, хөдөлгөөнөөр хичээллэж байна. Шаардлагагүй үедээ машин барилгүй алхдаг, гадаа ба фитнес зааланд гүйдэг, дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэдэг, штанг өргөдөг албан хаагчдын тоо 6-аар нэмэгдсэн. 	100
5.4.3	Дэлхийн Алтаргана-XV наадамд идэвх санаачилгатай оролцох,	-	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо		Дэлхийн Алтаргана-XV наадамд	<ul style="list-style-type: none"> Дэлхийн Алтаргана-XV наадамд салбарын хэмжээнд идэвхтэй оролцон, Эрүүл мэндийн газрын 28 , АНЭ-ийн 45, сум өрхийн 	100

	оролцогчдод дэмжлэг үзүүлэх				оролцогчдод дэмжлэг үзүүлсэн байна.	ЭМТ-ийн 78 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад төрийн албан хаагч нийт 153 хүн 12 суурин, 4 явуулын нэгжээр 24 цагаар эмнэлгийн яаралтай болон явуулын, суурин тусламж үйлчилгээг тасралтгүй зохион байгуулан ажилласан. <ul style="list-style-type: none"> • Наадмын өдрүүдэд нийт 354 хүнд амбулаторийн үзлэг хийгдэж, ОХУ-89, 1 БНХАУ-1, Монгол-263, бусад-1 улсын иргэд байсан. Нэгдсэн эмнэлгийн хүлээн авах яаралтай тусламжийн тасгаар 351 иргэн үйлчлүүлснээс 272 нь ердийн өвчлөл, 79 нь осол гэмтлийн шалтгаантай байсан байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан иргэдийн 62,1 хувь нь эрэгтэй, 37,9 хувь нь эмэгтэйчүүд байсан байна. 	
Зургаа. 2024 онд шинээр хийж, хэрэгжүүлэх шинэлэг ажил							
6.1.1	“Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлах	-	Жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	<ul style="list-style-type: none"> • НЭМ-ийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийн ханган ажиллаж байна. • “НЭМ-ийн дэмжих жил”-ийн ажлын хүрээнд дараах ахиц үр дүн гарсан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • “Эрүүл хүүхэд-Эрүүл шүд” арга хэмжээг орон нутагт амжилттай зохион байгуулан 0-17 насны 16872 хүүхэд буюу нийт хамрагдвал зохих хүүхдийн 77.2 хувийг үзлэгт хамруулж, өвчлөл илэрсэн хүүхдүүдийн 85.0 хувийг эмчилгээнд хамруулан, 40%-ийг нь бүрэн эмчилсэн байна. • “Шүд угаах цаг”-ийг эхлүүлж, 53 анги хэрэгжүүлж байна. • Хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүд нийгмийн хариуцлагын хүрээнд ЕБС-ийн 9612, СӨБ-ын 2270 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. • Улирал бүр уушиг, элэг, ходоод, умайн хүзүүний хавдрыг эрт илрүүлэх, урьдчилсан сэргийлэх 4 удаагийн аян зохион байгуулсан. 	90

					<ul style="list-style-type: none"> • Умайн хүзүүний хавдар илрүүлэх 3 сарын аяны хүрээнд 1590 эмэгтэйчүүдийг үзлэг оношлогоонд хамруулсан нь өмнөх 3 сарын үзүүлэлтээс 693 тохиолдлоор нэмэгдэж, сэжигтэй 42 тохиолдлыг дээд шатлалд илгээсэн байна. • Элэгний хавдарыг эрт илрүүлэх 3 сарын аянаар элэгний В, С вирусын ачаалал тоолох шинжилгээнд 36 хүнийг хамруулж, в вирусын эсрэг эмийн эмчилгээнд 16, С вирусын эмчилгээнд 20 хүнийг хамрууллаа. Элэгний С вирустэй 16 иргэн эмийн эмчилгээ дууссан. • Ходоодны хавдар илрүүлэх 3 сарын аянаар 123 хүнийг дурангийн шинжилгээнд хамруулсан нь өмнөх 3 сарын үзүүлэлтээс 90 тохиолдлоор нэмэгдсэн. Могод, Бугат сумд Орхон аймгийн Баян-Өндөрмөд эмнэлгийн дурангийн тасагтай хамтран 56 иргэнийг үзлэг оношлогоонд хамруулж, мэдээлэл, зөвлөгөө, заавар өгч ажилласан.
Зорилт – 6, Арга хэмжээ – 60					
Нийт хэрэгжилтийн хувь – 97.8 хувь					